

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2008 оны 7 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 185

Улаанбаатар хот

“Банк бус санхүүгийн байгууллагаас хөрөнгө
оруулалтын үйлчилгээ үзүүлэх түр журам”
батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Банк бус санхүүгийн байгууллагаас хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлэх түр журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, хөрөнгө оруулалтын тайланг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2. Өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлэх журмыг боловсруулан баталж, Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан Банк бус санхүүгийн байгууллагын Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
ТҮР ЖУРАМ

НЭГ . НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь банк бус санхүүгийн байгууллагуудаас /цаашид ББСБ гэх/ гаргасан санхүүгийн шинэ нэр төрлийн үйлчилгээг нэвтрүүлэх санал, санаачлагыг Санхүүгийн зохицуулах хорооноос /цаашид Хороо гэх/ бодлогоор дэмжих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах, учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээс сэргийлэх, хяналт тавих харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Хөрөнгө оруулалтын үйлчилгээг Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, энэ үйлчилгээг эрхлэх хүсэлтээ гаргасан, тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд / ББСБ/ эрхэлнэ.
- 1.3. Хөрөнгө оруулалтын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох болон бусад зохицуулалтыг “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын дагуу шийдвэрлэнэ.

ХОЁР. НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

- 2.1. “Хөрөнгө оруулалтын үйлчилгээ” гэж хөрөнгө оруулалтын гэрээгээр ББСБ өөрийн хөрөнгөөс үйлчлүүлэгч хязгаарлагдмал хариуцлагатай компанийн /цаашид компани гэх/ хувьцааны тодорхой хэсгийг гэрээнд заасан хугацаанд эзэмших замаар хөрөнгө оруулалт хийж, санхүүгийн менежментийг удирдан явуулах санхүүгийн үйлчилгээг;
- 2.2. “Хөрөнгө оруулалтын гэрээ” гэж Иргэний хуулийн 406 дугаар зүйл болон энэ журамд заасныг удирдлага болгон Банк бус санхүүгийн байгууллага, үйлчлүүлэгч компанийн хооронд бичгээр үйлдсэн тохиролцоог;
- 2.3. “Хөрөнгө оруулагч” гэж банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хөрөнгө оруулалтын үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авч, өөрийн дүрмийн сангаас хаалттай компанийн /ХХК/ дүрмийн санд тодорхой хугацаанд хөрөнгө оруулах ББСБ-ыг;
- 2.4. “Үйлчлүүлэгч компани” гэж өөрийн хувьцааны тодорхой хэсгийг гэрээнд заасан хугацаанд эзэмшүүлэх замаар дүрмийн сандаа хөрөнгө оруулалт хийхийг зөвшөөрсөн компанийг.

ГУРАВ. ББСБ-ЫН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Хөрөнгө оруулах үйлчилгээ эрхлэх ББСБ нь дараах эрх эдэлнэ. Үүнд:
 - 3.1.1. Хөрөнгө оруулалтын үйлчилгээг авахыг хүссэн компанийн бизнесийн, санхүүгийн болон бусад шаардлагатай мэдээлэлтэй танилцах;

- 3.1.2. Үйлчлүүлэгч компанийн удирдлагын чадавхи, бизнес төлөвлөгөө болон бизнесийн үйл ажиллагаанд магадлан шалгалт, шинжилгээ хийж, хөрөнгө оруулалт хийх шийдвэрээ гаргах;
 - 3.1.3. Үйлчлүүлэгч компанийн хувьцааны тодорхой хэсгийг тодорхой хугацаанд эзэмшсэний үндсэн дээр дүрмийн санд хөрөнгө оруулалт хийх;
 - 3.1.4. Хөрөнгө оруулах гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш үйлчлүүлэгч компанийн бизнесийн үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох бүртгэл тайлан мэдээг шаардах;
 - 3.1.5. Хөрөнгө оруулалтын гэрээгээр тохиролцсон ашиг /үр шим/-ийг хүртэх;
 - 3.1.6. Хөрөнгө оруулалтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах тухай санал гаргах;
 - 3.1.7. Хөрөнгө оруулалтын гэрээнээс үүдэн гарсан аливаа маргааны талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;
 - 3.1.8. Хууль тогтоомжоор заасан бусад эрх;
- 3.2. Хөрөнгө оруулах үйлчилгээ эрхлэх ББСБ нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:
- 3.2.1. Хөрөнгө оруулалтын үйлчилгээ эрхлэхийг хүссэн ББСБ нь “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 5.2 заасны дагуу баримт бичгийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ.
 - 3.2.2. Хөрөнгө оруулах гэрээнд заасан хөрөнгийг үйлчлүүлэгч компанид шилжүүлэх;
 - 3.2.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий ББСБ нь хөрөнгө оруулалтын үйлчилгээг банк бус санхүүгийн бусад үйл ажиллагаатай хослуулан эрхлэх;
 - 3.2.4. ББСБ нь хөрөнгө оруулалтын үйлчилгээний журмаа боловсруулан, баталж Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ.
 - 3.2.5. Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтмол хангаж ажиллах;
 - 3.2.6. Хөрөнгө оруулалтын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ББСБ сарын санхүүгийн, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн болон хөрөнгө оруулалтын тайланг дараа сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ.
 - 3.2.7. Хөрөнгө оруулалтын эрсдэлийг удирдах, хяналт тавих зүй зохистой тогтолцоог бүрдүүлсэн байна.

**ДӨРӨВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЛЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- 4.1. Хөрөнгө оруулалтын үйлчилгээ эрхлэхэд дараах шаардлага тавигдана. Үүнд

- 4.1.1 ББСБ нь хөрөнгө оруулалтын үйлчилгээг Хорооны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ.
- 4.1.2 Хөрөнгө оруулалтын үйлчилгээг эрхлэх ББСБ-ын дүрмийн сангийн хэмжээ нь 1,000,000,000 /нэг тэрбум/ төгрөгөөс доошгүй байна.
- 4.1.3 Хөрөнгө оруулалтын үйлчилгээ нь 2-оос доошгүй жилийн хугацаатай байна.
- 4.1.4 Хөрөнгө оруулалтын нийт хэмжээ нь тухайн банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгийн 50 хувиас дээшгүй байна.
- 4.1.5 Хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлэгч ББСБ нь үйлчлүүлэгч компанийн хувьцааны 49 хувиас дээшгүй хувийг эзэмшинэ.
- 4.1.6 Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангасан байна.
- 4.1.7 Хөрөнгө оруулагч ББСБ нь хөрөнгө оруулсан хөрөнгийг даатгуулж болно.
- 4.1.8 Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ББСБ-ын хүсэлтийг үндэслэн хөрөнгө оруулалтын үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг Хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ.
- 4.1.9 ББСБ нь хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлж буй компани тус бүрт хувийн хэрэг нээж хөтөлнө. Хувийн хэрэгт хөрөнгө оруулалтын ерөнхий гэрээ, компанийн дүрэм болон компанийн удирдах болон дотоодод мөрдөж буй дүрэм, журмууд, хөрөнгө оруулалттай холбогдсон бүх баримт бичгийг хавсаргана.

ТАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХЭД ХОРИГЛОХ ЗҮЙЛ

- 5.1 Хөрөнгө оруулалтын үйлчилгээ эрхлэхэд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
Үүнд:
 - 5.1.1 Хөрөнгө оруулалтын үйлчилгээний талаар худал, ташаа зар сурталчилгаа, мэдээ, мэдээлэл хийх;
 - 5.1.2 Хөрөнгө оруулалтын үйлчилгээ нь тодорхой хугацаагүй байх;
 - 5.1.3 ББСБ-ын санхүүгийн тайлан тэнцэлд тусгагдаагүй мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг хөрөнгө оруулалтын үйлчилгээнд ашиглах;
 - 5.1.4 Бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрээр хөрөнгө оруулалт хийх;
 - 5.1.5 Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлгүйгээр хөрөнгө оруулалтын үйлчилгээ эрхлэх;
 - 5.1.6 Үйлчлүүлэгч компани нь ББСБ-ын оруулсан хөрөнгө оруулалтыг гэрээнд зааснаас өөр зориулалтаар ашиглах.

ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ДУУСГАВАР БОЛОХ

- 6.1 Хорооноос хөрөнгө оруулалтын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ББСБ болон үйлчлүүлэгч компани харилцан тохиролцсоны үндсэн дээр хөрөнгө оруулалтын гэрээг байгуулна.
- 6.2 Хөрөнгө оруулалтын гэрээг Иргэний хуулийн 406 дугаар зүйлд заасны дагуу бичгээр байгуулна.
- 6.3 Хөрөнгө оруулалтын гэрээнд дараах зүйлийг заавал тусгасан байна. Үүнд:
 - 6.3.1 Гэрээнд оролцогч талуудын нэр, хаяг, утас, гэрчилгээний дугаар, төлөөлөх этгээд гэх мэт;
 - 6.3.2 Гэрээний ерөнхий болон үе шатны хугацаа;
 - 6.3.3 Хөрөнгө оруулалтын нийт хэмжээ, хөрөнгө оруулалтын график;
 - 6.3.4 Талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлага;
 - 6.3.5 Компанийн дүрэмд тусгах удирдлага, зохицуулалт, хяналтын тогтолцоо, удирдах байгууллагуудын эрх хэмжээ гэх мэт ерөнхий зарчим;
 - 6.3.6 Хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх хэлбэр, нөхцөл, журам /компани өөрийн хувьцааг худалдан авах, гуравдагч этгээдэд шилжүүлэх, нийтэд зарлах гэх мэт/;
 - 6.3.7 Компанийн үйл ажиллагааг тайлагнах хугацаа, үйл ажиллагааны явцын талаарх мэдээлэл авах хэлбэр;
 - 6.3.8 Нэмэлт хөрөнгө оруулалт хийх нөхцөл, шаардлага, зохицуулалт;
 - 6.3.9 Ногдол ашиг болон бусад хүртэж болох үр ашиг, үр шим, хуваарилах зарчим;
 - 6.3.10 Эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаарх талуудын үүрэг, хариуцлага;
 - 6.3.11 Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих нөхцөл, шаардлага;
 - 6.3.12 Удирдлага, зохион байгуулалт болон компанийн дүрэмд орох өөрчлөлтийг зохицуулах зарчим;
 - 6.3.13 Гэрээг дүгнэх, үүдэн гарах үр дагавар, зохицуулалт;
 - 6.3.14 Гэрээ дуусгавар болгох нөхцөл.

ДОЛОО. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ХЯНАЛТ

- 7.1 Оруулсан хөрөнгийг нь хууль тогтоомж болон хөрөнгө оруулалтын гэрээний дагуу захиран зарцуулж байгаа эсэхэд хөрөнгө оруулагч /ББСБ/ хяналт тавина.
- 7.2 Хороо нь хөрөнгө оруулалтын үйлчилгээ эрхэлж байгаа ББСБ-ын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгаа эсэхийг сар тутмын санхүүгийн тайлангаар хянах ба шаардлагатай гэж үзвэл газар дээрх шалгалтыг хийж, холбогдох арга хэмжээ авна.

НАЙМ. ХАРИУЦЛАГА

- 8.1 Хөрөнгө оруулалтын үйлчилгээ эрхэлж байгаа ББСБ энэхүү журамд заасан шаардлага болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй, цаашид болзошгүй эрсдэл үүсэх магадлалтай болсон нөхцөлд Хорооноос дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:
 - 8.1.1 ББСБ-ын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлага тавих;
 - 8.1.2 Хөрөнгө оруулалтын үйлчилгээнд нэмж хөрөнгө оруулахыг хориглох;
 - 8.1.3 Хөрөнгө оруулалтын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх;
 - 8.1.4 Хөрөнгө оруулалтын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох.
- 8.2 Хөрөнгө оруулалтын үйлчилгээг эрхлэхдээ энэхүү журмыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хууль тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ.
- 8.3 Хөрөнгө оруулалтын үйлчилгээтэй холбоотой гарсан аливаа маргааныг хөрөнгө оруулалтын гэрээ болон холбогдох хууль тогтоомжийг үндэслэн эрх бүхий хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

-- ооОоо --

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хөрөнгө оруулалтын үйлчилгээ үзүүлсэн ХХК-ийн нэр	Хөрөнгө оруулалтын үйлчилгээний гэрээний хугацаа	Хөрөнгө оруулалтын хэмжээ /төгрөгөөр/	Үйлчлүүлэгч компанийн хувьцаанаас ББСБ-ын эзэмшсэн хувьцааны	
			Тоо хэмжээ	Хувь
1				
2				
3				
4				
5				
Дүн				

Тайлан гаргасан:

Дарга

Нягтлан бодогч